



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Өвөрхангай аймгийн статистикийн хэлтэс
2021 он

Танилцуулга

Судалгааны зорилго

1. Судалгаанд хамрагдалт

1.1.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО, ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР	3
1.2.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО, ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР	3
1.3.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН ТОО, ЗЭРЭГ ДЭВИЙН АНГИЛАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР	4
1.4.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО, АЛБАНЫ ТУШААЛЫН ТӨРӨЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР	4
1.5.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО, АЛБАНЫ ТУШААЛЫН ТӨРӨЛ, СУМДАД ЭЗЛЭХ ХУВИАР	5

2. Үндэсний бичгээ хэрэглэхэд бэлэн эсэх

2.1.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД АЛБАН ХЭРГЭЭ КРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН ЭСЭХ, ХУВИАР	5
2.2.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД АЛБАН ХЭРГЭЭ КРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН ЭСЭХ, СУМДАД ЭЗЛЭХ ХУВИАР	6

3. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг

3.1.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР ...	6
3.2.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР	7
3.3.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ, ХУВИАР	8
3.4.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, АЛБАН ТУШААЛЫН ТӨРӨЛ, ХУВИАР	8
3.5.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР	8
3.6.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, СУМ, ХУВИАР	9

4. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн унших чадвар

4.1.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ӨГӨГДСӨН ЭХ УНШИХ ЧАДВАР, ХУВИАР	9
4.2.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ӨГӨГДСӨН ЭХ УНШИХ ЧАДВАР ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮЗСЭН ЖИЛ, ХУВИАР	10
4.3.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮЗСЭН ЖИЛ, СУМ, ХУВИАР ...	10
4.4.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ӨГӨГДСӨН ЭХ УНШИХ ЧАДВАР, АЛБАН ТУШААЛЫН ТӨРӨЛ, ХУВИАР	11
4.5.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ӨГӨГДСӨН ЭХ УНШИХ ЧАДВАР, СУМ, ХУВИАР ..	11

5. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн бичих чадвар

5.1.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР БИЧИХ ЧАДВАР, НАСНЫ АНГИЛАЛ, ХУВИАР	12
5.2.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР БИЧИХ ЧАДВАР, ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ, ХУВИАР	13
5.3.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР БИЧИХ ЧАДВАР, СУМ, ХУВИАР	13

6. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн сургалтын хэрэгцээ

6.1.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ...	14
6.2.	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТЫН ХЭЛБЭР, СУМ, ХУВИАР	14

7. Дүгнэлт

8. Хавсралт, хүснэгт.....

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их хурлаас 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр “Монгол хэлний тухай” хуулийг баталж, 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Уг хуульд үндэсний бичигтэй холбоотой дараах заалтыг тусгажээ. Үүнд:

7 дугаар зүйлийн 2-т энэ хуулийн 11.1.2-т заасан “Үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна”

11 дүгээр зүйлийн 1.2-т “Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх”

24 дүгээр зүйлийн 2-т 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Мөн хуулийн хэрэгжилтийг хангахаар даган гарсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-2020-2024”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлж, Монгол Улсын “Монгол хэлний тухай” хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III (2020-2024)”-ын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх, цаашид үндэсний бичгийн талаар төрөөс авч, хэрэгжүүлэх бодлого, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулахад шаардлагатай тоо, мэдээллийг бий болгоход оршино.

Мөн төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлсоноор Монгол хэлний тухай хуулийг дагаж мөрдөхөд бэлэн эсэх, цаашид үндэсний бичгийг төрийн албан ёсны үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд хэрэгцээтэй үе шаттай сургалтын төлөвлөгөө боловсруулахад мөн ашиглагдах юм.

1. СУДАЛГААНЫ ХАМРАГДАЛТ

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (цаашид “ХНУМТ” гэх) цахим систем”-д байгаа төрийн бүх шатны байгууллагын албан хаагчдын “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГИЙГ ТОДОРХОЙЛОХ” судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 04 дүгээр сарын 5-наас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны хооронд Өвөрхангай аймагт зохион байгууллаа.


Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаанд нийт 160 мянга орчим хүний мэдээллийг ҮСХ-ны “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”-ын мэдээллийн сангаас гаргаж, хүн бүрт тусгай эрх, нууц үгийг олгох замаар цахим орчинд мэдээлэл цуглуулсан нь дэвшилтэт үйл явдал байлаа.

Өвөрхангай аймгаас Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаанд 5794 төрийн албан хаагч хамрагдсан бөгөөд улс төрийн албан хаагч 329 буюу

5.7 хувь, төрийн захиргааны албан хаагч 648 буюу 11.2 хувь, төрийн тусгай албан хаагч 80 буюу 1.4 хувь, төрийн үйлчилгээний албан хаагч 4737 буюу 81.8 хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдыг хүйсээр нь авч үзвэл 4169 буюу 72.0 хувь нь эмэгтэйчүүд, 1625 буюу 28.0 хувь нь эрэгтэйчүүд байна. Төрийн албанд ажиллаж буй эмэгтэйчүүдийн дийлэнх буюу 75.6 хувь нь төрийн үйлчилгээний албанд, 33.4 хувь нь улс төрийн алба тушаалд ажиллаж байна. (Зураг 1.1, 1.2)

Зураг 1.1, 1.2. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо төрийн албаны ангилал, хүйс, хувиар




Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын аль ч насны бүлэгт төрийн үйлчилгээний албан хаагч ихэнх хувийг эзэлж байгаа бөгөөд төрийн тусгай албан хаагчид бүх насны бүлэгт бага хувийг эзэлж байгаа нь төрийн тусгай албан хаагчдаас зөвхөн шүүх, прокурорын албан хаагчид судалгаанд хамрагдсантай холбоотой юм. (Зураг 1.3)

Зураг 1.3. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо төрийн албаны ангилал, насны бүлэг, хувиар




Судалгаанд хамрагдсан төрийн захиргааны албан хаагчдыг зэрэг дэвийн байдлаар авч үзвэл дийлэнх хувь буюу 55.0 хувийг дэс түшмэлийн ангилалд ажиллаж буй албан хаагчид эзэлж байна. Харин эрхэлсэн түшмэлийн ангилалд ажиллаж буй албан хаагчид хамгийн бага буюу 0.02 хувийг эзэлж байна. (Зураг 1.4)

Зураг 1.4. Судалгаанд хамрагдсан төрийн захиргааны албан хаагчдын тоо, зэрэг дэвийн ангилал, насны бүлэг, хувиар



Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдыг албан тушаалын төрлөөр авч үзвэл удирдах албан тушаалд 9.9 хувь, гүйцэтгэх албан тушаалд 61.0 хувь, туслах албан тушаалд 29.1 хувь нь ажиллаж байна. Удирдах албан тушаалын дийлэнх буюу 20.0 хувийг 35-39 насныхан эзэлж байгаа бол гүйцэтгэх албан тушаалын төрөлд ажиллаж буй албан хаагчдын дийлэнх хувь буюу 20.8 хувийг 30-34 насныхан, туслах албан тушаалын дийлэнх буюу 15.8 хувийг 50-54 насныхан эзэлж байна. (Зураг 1.5)


Зураг 1.5. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо, албаны тушаалын төрөл, насны бүлгээр



Судалгаанд хамрагдсан удирдах албан тушаалд ажиллагсадаас хамгийн их буюу 19.3 хувийг Гучин-Ус сумын удирдах албан тушаалтнууд эзэлж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан гүйцэтгэх албан тушаалд ажиллагсадын хамгийн их нь буюу 77.8 хувь нь Есөнзүйл сумын албан хаагчид эзэлж байна. Туслах албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдаас Нарийнтээл сумын албан хаагчид хамгийн их буюу 38.7 хувийг эзэлж байна.

(Зураг 1.6)


Зураг 1.6. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо, албаны тушаалын төрөл, сумдад эзлэх хувиар



2. ҮНДЭСНИЙ БИЧГЭЭ ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН ЭСЭХ


Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 53.1 хувь нь албан хэргээ крилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулсан бол 46.9 хувь нь бэлэн биш гэж хариулсан байна. (Зураг 2.1, 2.2)

Зураг 2.1, 2.2. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчид албан хэргээ крилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, хувиар



Судалгаанд хамрагдсан албан хаагчид албан хэргээ крилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх асуултанд хамгийн өндөр нь Бүрд сумын төрийн албан хаагчдын 75.8 хувь, Сант сумын төрийн албан хаагчдын 72.1 хувь, Тарагт сумын албан хаагчдын 64.2 хувь нь хэрэглэхэд бэлэн гэж хариулсан байна. Харин Хайрхандулаан сумын төрийн албан хаагчдын 48.1 хувь, Бат-Өлзий сумын төрийн албан хаагчдын 40.0 хувь, Баруунбаян-Улаан сумын төрийн албан хаагчдын 38.3 хувь нь тийм гэж хариулсан нь бага хувийг эзэлж байна. (Зураг 2.3)


Зураг 2.3. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчид албан хэргээ крилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, сумдад эзлэх хувиар



3. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ


Судалгаанд хамрагдсан нийт төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлоход 5.4 хувь нь маш сайн, 12.3 хувь нь сайн мэддэг гэж хариулсан бол 25.1 хувь нь үгүй, мэдлэггүй гэж хариулсан байна. Үндэсний бичгээ маш сайн мэддэг төрийн албан хаагчдын 85.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол үндэсний бичгээ бага зэрэг мэддэг, мэддэггүй гэж хариулсан төрийн албан хаагчид дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна. (Зураг 3.1, 3.2)

Зураг 3.1, 3.2. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, хүйс, хувиар




Үндэсний бичгээ ямар нэгэн байдлаар мэддэг гэж хариулсан төрийн албан хаагчид дотроос маш сайн, сайн мэддэг гэж хариулсан хүмүүсийн дийлэнх хувь нь 35-49 насныхан байгаа бол дунд зэрэг мэддэг хүмүүсийн дийлэнх хувийг 15-24, 65-69 насныхан эзэлж байна. Мөн мэддэггүй гэж хариулсан хүмүүсийн дийлэнх нь 50-аас дээш насныхан байна. (Зураг 3.3)

Зураг 3.3. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, насны бүлэг, хувиар




Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын төрийн албаны ангиллаар төрийн үйлчилгээний албан хаагч үндэсний бичгийн мэдлэгийн тухай аль ч асуултанд дийлэнх хувийг эзэлж байна. Энэ нь нийт төрийн албан хаагчдын дийлэнх хувь нь төрийн үйлчилгээний албан хаагчид байдагтай холбоотой. (Зураг 3.4)

Зураг 3.4. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, төрийн албаны ангилал, хувиар




Удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны дийлэнх хувь нь маш сайн, сайн мэддэг гэж хариулсан байхад туслах албан тушаалтны дийлэнх буюу 52.5 хувь мөн үгүй, мэдлэггүй гэж хариулсан байна. (Зураг 3.5)

Зураг 3.5. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, албан тушаалын төрөл, хувиар



Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдаас үндэсний бичгээ маш сайн, сайн болон дунд зэрэг мэддэг хүмүүсийн дийлэнх хувийг баклаврын түвшний боловсролтой хүмүүс эзэлж байна. Харин үндэсний бичгийн мэдлэггүй гэж хариулсан хүмүүсийн ихэнх хувийг суурь, бүрэн дунд, боловсролтой төрийн албан хаагчид эзэлж байна. (Зураг 3.6)


Зураг 3.6. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, боловсролын түвшин, хувиар



Үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох асуултанд Сант, Баянгол, Хужирт сумдын төрийн албан хаагчид бусад сумдын төрийн албан хаагчдаас маш сайн болон сайн гэж хариулсан хувь нь илүү байгаа бол Богд, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын төрийн албан хаагчдын маш сайн болон сайн гэсэн хариулт бусад сумдаас хамгийн бага байна. Ер нь үндэсний бичгээ бага ч гэсэн мэднэ гэж төрийн албан хаагчдын ихэнх нь хариулсан байна.

Мөн эдгээр сумдын үндэсний бичиг мэддэггүй төрийн албан хаагчийн тоо хамгийн бага буюу Бүрд 10.6 хувь, Сант 17.9 хувь байна. Харин Бат-Өлзий сумын төрийн албан хаагчдын 38.9 хувь, Богд сумын төрийн албан хаагчдын 35.2 хувь, Хайрхандулаан сумдын төрийн албан хаагчдын 34.8 хувь нь үндэсний бичгээ мэддэггүй гэж хариулсан нь бусад сумдаас харьцангуй өндөр хувьтай байна. (Зураг 3.7)


Зураг 3.7. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, сум, хувиар




4. УНШИХ ЧАДВАР

Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдаас өгөгдсөн эхийн зарим хэсгийг унших чадвартай гэж хариулсан хүмүүс дийлэнх буюу 51.0 хувь, бүтнээр унших чадвартай 38.2 хувь гэж хариулсан бол 10.8 хувь нь огт уншиж чадаагүй гэж хариулжээ. (Зураг 4.1)

Зураг 4.1. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын өгөгдсөн эх унших чадвар, хувиар




Зураг 4.2. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын өгөгдсөн эх унших чадвар үндэсний бичиг үзсэн жил, хувиар




Үндэсний бичиг 3-аас дээш жил сурсан төрийн албан хаагчид дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд үндэсний бичгийг олон жил сурах тусам төрийн албан хаагчдын унших чадвар илүү сайн байгаа нь харагдаж байна. Харин үндэсний бичгийг цөөн жил буюу 1-2 жил сурсан албан хаагчдын дийлэнх хувь нь өгөгдсөн эхийн зарим хэсгийг унших чадвартай гэж хариулсан байна. (Зураг 4.2)

Зураг 4.3. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичиг үзсэн жил, сум, хувиар




Бүтнээр унших чадвартай гэж хариулсан албан хаагчдын дийлэнх буюу 74.4 хувийг гүйцэтгэх албан тушаалын төрөлд ажиллаж буй албан хаагчид эзэлж байгаа бол огт уншиж чадаагүй гэж хариулсан албан хаагчдын дийлэнх хувийг туслах албан тушаалын төрөлд ажиллаж буй албан хаагчид эзэлж байна. (Зураг 4.4)

Зураг 4.4. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын өгөгдсөн эх унших чадвар, албан тушаалын төрөл, хувиар



Сумдын дүнгээс харахад бүтнээр болон зарим хэсгийн унших чадвартай төрийн албан хаагчдын тоо бүх сумдад өндөр хувьтай байна. Харин огт уншиж чаддаггүй төрийн албан хаагчийн тоо Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Есөнзүйл сумдад өндөр байгаа бол Тарагт, Бүрд, Хайрхандулаан сумдад бусад сумдаас хамгийн бага хувьтай байна. (Зураг 4.5)

Зураг 4.5. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын өгөгдсөн эх унших чадвар, сум, хувиар




5. БИЧИХ ЧАДВАР

Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдаас үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй хүмүүсийн 13.1 хувь нь үндэсний бичгээ сайн бичиж чадна гэж хариулсан бол 38.0 хувь нь дунд зэрэг, 40.2 хувь нь бага зэрэг бичиж чадна гэж хариулжээ. Харин 8.7 хувь нь огт бичиж чадахгүй гэж хариулсан байна.


Үндэсний бичгийн бичих чадварын асуултанд ямар нэгэн байдлаар бичиж чадна гэж хариулсан албан хаагчдаас баклаврын түвшний боловсролтой албан хаагчид дийлэнх буюу 59.3 хувь байна. Насны бүлгээр авч үзвэл, маш сайн бичиж чадна гэж хариулсан албан хаагчдын дийлэнх хувийг 35-44 насныхан эзэлж байгаа бол үгүй бичиж чадахгүй гэж хариулсан албан хаагчид дотор 30-34 насныхан ихэнх хувийг эзэлж байна. (Зураг 5.1, 5.2)

Зураг 5.1, 5.2. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгээр бичих чадвар, насны бүлэг, боловсролын түвшин, хувиар



Маш сайн бичиж чадна гэж хариулсан төрийн албан хаагчдын дийлэнх буюу 84.6 хувийг төрийн үйлчилгээний албан хаагчид эзэлж байгаа бөгөөд хамгийн бага хувийг төрийн тусгай албан хаагчид эзэлж байна. Ерөнхийдөө бичих чадварын аль ч асуултанд төрийн үйлчилгээний албан хаагчид дийлэнх хувийг эзэлж байгаа нь нийт төрийн албан хаагчид дотор үйлчилгээний албан хаагчийн эзлэх хувь өндөр байгаатай холбоотой юм. (Зураг 5.3)


Зураг 5.3. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгээр бичих чадвар, төрийн албаны ангилал, хувиар



Бичих чадварын сайн, дунд, бага зэрэг бичиж чадна гэсэн хариултыг Сант, Төгрөг, Бат-Өлзий сумдын төрийн албан хаагчид бусад сумдаас харьцангуй өндөр хувьтай хариулсаны дээр эдгээр сумдын үндэсний бичгээр бичиж чадахгүй гэж хариулсан албан хаагчдын тоо бусад сумдаас хамгийн бага байна.

Харин Баян-Өндөр, Нарийнтээл, Богд сумдын төрийн албан хаагчдын үндэсний бичгээр бичиж чадахгүй гэж хариулсан хариулт бусад сумдаас өндөр хувьтай байна.

Зураг 5.4. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгээр бичих чадвар, сум, хувиар



6. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ

Нийт төрийн албан хаагчдын 88.0 хувь нь сургалтанд хамрагдах хэрэгтэй гэж үзсэн бол 12.0 хувь нь шаардлагагүй гэж үзжээ.

Үндэсний бичгийн сургалтанд сурах хэрэгцээ шаардлага байгаа эсэх асуултанд 55-аас дээш насныхан тийм гэж хариулсан хариулт дийлэнх байгаа бол залуучууд буюу 20-34 насныхан сургалтанд сурах хэрэгцээ шаардлага байхгүй хариулсан нь дийлэнх байна. Энэ нь сүүлийн жилүүдэд ЕБС-д үндэсний бичгийн хичээл 6 дугаар ангиас зааж байгаатай холбоотой юм. (Зураг 6.1)

ДҮГНЭЛТ

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаанд Өвөрхангай аймгаас 5794 төрийн албан хаагч оролцсон байна.

Судалгаанд оролцсон нийт төрийн албан хаагчдын улс төрийн албан хаагч 5.7 хувь, төрийн захиргааны албан хаагч 11.2 хувь, төрийн тусгай албан хаагч 1.4 хувь, төрийн үйлчилгээний албан хаагч 81.8 хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 72.0 хувь нь эмэгтэйчүүд, 28.0 хувь нь эрэгтэйчүүд байлаа. Төрийн үйлчилгээний албанд эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь буюу 75.6 ажиллаж байхад харин улс төрийн алба тушаалд ажиллаж байгаа эмэгтэйчүүд хамгийн бага буюу 33.4 хувийг эзэлж байна.

Нийт төрийн албан хаагчдын 53.1 хувь нь крилл болон үндэсний бичгээр албан хэргээ хөтлөхөд бэлэн гэж хариулсан бол 46.9 хувь нь бэлэн биш гэж хариулсан байна.

Төрийн албан хаагчдын 75.0 хувь нь үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй, үүнээс 24.0 хувь нь маш сайн болон сайн мэддэг гэж хариулсан байна. Харин нийт төрийн албан хаагчдын 25.0 хувь нь огт мэдлэггүй гэж хариулжээ.

Үндэсний бичгийн мэдлэгийг боловсролын түвшингээр авч үзвэл үндэсний бичгээ тодорхой түвшинд мэддэг хүмүүсийн дийлэнх хувь нь баклавын түвшний боловсролтой хүмүүс байна. Харин үндэсний бичгийн мэдлэггүй гэж хариулсан төрийн албан хаагчдын ихэнх хувийг суурь, бүрэн дунд, баклавын боловсролтой төрийн албан хаагчид эзэлж байна.

Үндэсний бичгийн мэдлэгийг насны бүлгээр авч үзвэл ямар нэгэн байдлаар мэддэг гэж хариулсан төрийн албан хаагчид дотроос маш сайн, сайн мэддэг гэж хариулсан хүмүүсийн дийлэнх хувь нь 35-49 насныхан эзэлж байгаа бол дунд зэрэг мэддэг хүмүүсийн дийлэнх хувийг 15-24, 65-69 насныхан эзэлж байна. Мөн мэддэггүй гэж хариулсан хүмүүсийн дийлэнх хувийг 50-аас дээш насныхан эзэлж байна. Энэ нь 1985 оноос ЕБС-ийн 7 дугаар ангиас үндэсний бичгийн хичээл зааж эхэлсэнтэй холбон үзэж болно. Мөн 1992 онд Монгол Улс анх удаа ЕБС-ийн 1 дүгээр ангиас үндэсний бичгийн Цагаан толгой зааж байсантай бас холбон үзэж болох юм.

Үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй төрийн албан хаагчдын дийлэнх буюу 51.0 хувь нь зарим хэсгийн унших чадвартай байсан бол 38.2 хувь нь бүтнээр унших чадвартай гэж хариулжээ. Харин 10.8 хувь нь үндэсний бичгээр бичсэн энгийн өгүүлбэрийг огт уншиж чаддаггүй байна.

Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдаас үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй хүмүүсийн 13.1 хувь нь үндэсний бичгээ сайн бичиж чадна гэж хариулсан бол 38.0 хувь нь дунд зэрэг, 40.2 хувь нь бага зэрэг бичиж чадна гэж хариулжээ. Харин 8.7 хувь нь огт бичиж чадахгүй гэж хариулсан байна.

Нийт төрийн албан хаагчдын 88.0 хувь нь сургалтанд хамрагдах хэрэгтэй гэж үзсэн бол 12.0 хувь нь шаардлагагүй гэж үзжээ. Үндэсний бичгийн сургалтанд хамрагдах сурах хэрэгцээ шаардлага байгаа эсэх асуултанд 55-аас дээш насныхан тийм гэж хариулсан

хариулт дийлэнх байгаа бол залуучууд буюу 20-34 насныхан сургалтанд сурах хэрэгцээ шаардлага байхгүй хариулсан нь дийлэнх байна.

Сургалтанд хамрагдах шаардлагатай гэж үзсэн төрийн албан хаагчдын 22.5 хувь нь онлайнаар, 68.0 хувь нь танхимаар, 8.6 хувь нь онлайн болон танхимын хэлбэрээр, 0.9 хувь нь бусад хэлбэрээр сурах хүсэлтэй гэж хариулжээ.

7. ХАВСРАЛТ ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчийн тоо, төрийн албаны ангилал, сум, хүйсээр

	Бүгд			Төрийн улс төрийн алба			Төрийн захиргааны алба		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	5794	1625	4169	329	219	110	648	215	433
Арвайхээр	2130	531	1599	61	20	41	314	95	219
Баруунбаян-Улаан	146	44	102	13	12	1	14	4	10
Бат-Өлзий	270	68	202	13	8	5	18	6	12
Баян-Өндөр	168	55	113	10	8	2	17	6	11
Баянгол	147	43	104	16	14	2	15	7	8
Богд	208	60	148	20	13	7	12	5	7
Бүрд	124	36	88	10	6	4	13	4	9
Гучин-Ус	130	42	88	13	9	4	16	3	13
Есөн зүйл	131	38	93	11	9	2	15	8	7
Зүүнбаян-Улаан	148	60	88	17	14	3	15	8	7
Нарийнтээл	194	78	116	10	9	1	19	7	12
Өлзийт	120	42	78	8	7	1	19	10	9
Сант	151	43	108	12	10	2	11	6	5
Тарагт	140	41	99	16	10	6	12	2	10
Төгрөг	160	35	125	17	13	4	17	2	15
Уянга	356	104	252	32	22	10	25	7	18
Хайрхандулаан	164	54	110	14	12	2	21	6	15
Хархорин	646	189	457	18	13	5	59	22	37
Хужирт	261	62	199	18	10	8	16	7	9

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

	Төрийн тусгай алба			Төрийн үйлчилгээний алба		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	80	33	47	4737	1158	3579
Арвайхээр	48	19	29	1707	397	1310
Баруунбаян-Улаан	5	4	1	114	24	90
Бат-Өлзий	1	0	1	238	54	184
Баян-Өндөр	0	0	0	141	41	100
Баянгол	0	0	0	116	22	94
Богд	1	1	0	175	41	134
Бүрд	2	2	0	99	24	75
Гучин-Ус	2	1	1	99	29	70
Есөн зүйл	2	0	2	103	21	82
Зүүнбаян-Улаан	0	0	0	116	38	78
Нарийнтээл	2	1	1	163	61	102
Өлзийт	0	0	0	93	25	68
Сант	1	0	1	127	27	100
Тарагт	2	2	0	110	27	83
Төгрөг	3	0	3	123	20	103
Уянга	0	0	0	299	75	224
Хайрхандулаан	1	0	1	128	36	92
Хархорин	9	3	6	560	151	409
Хужирт	1	0	1	226	45	181

Хүснэгт 2.1. Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, албан тушаалын ангилал, төрөл, төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын ангилал,хүйсээр

	Бүгд			Бүгд	Тийм			Үгүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
Бүгд	5794	1625	4169	3076	787	2289	2718	838	1880	
Төрийн улс төрийн алба	329	219	110	189	121	68	140	98	42	
Төрийн захиргааны алба	648	215	433	331	112	219	317	103	214	
Төрийн тусгай алба	80	33	47	35	11	24	45	22	23	
Төрийн үйлчилгээний алба	4737	1158	3579	2521	543	1978	2216	615	1601	
Бүгд	5794	1625	4169	3076	787	2289	2718	838	1880	
Удирдах	566	272	294	321	146	175	245	126	119	
Гүйцэтгэх	3537	835	2702	2045	461	1584	1492	374	1118	
Туслах	1691	518	1173	710	180	530	981	338	643	
Бүгд	648	215	433	331	112	219	317	103	214	
Эрхэлсэн түшмэл	9	5	4	6	3	3	3	2	1	
Ахлах түшмэл	87	42	45	41	22	19	46	20	26	
Дэс түшмэл	357	99	258	171	44	127	186	55	131	
Туслах түшмэл	195	69	126	113	43	70	82	26	56	

Хүснэгт 2.2. Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, сум, хүйсээр

	Бүгд			Бүгд	Тийм			Үгүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
Бүгд	5794	1625	4169	3076	787	2289	2718	838	1880	
Арвайхээр	2130	531	1599	1067	243	824	1063	288	775	
Баруунбаян-Улаан	146	44	102	56	16	40	90	28	62	
Бат-Өлзий сум	270	68	202	108	17	91	162	51	111	
Баян-Өндөр	168	55	113	94	33	61	74	22	52	
Баянгол	147	43	104	87	21	66	60	22	38	
Богд	208	60	148	112	30	82	96	30	66	
Бүрд	124	36	88	94	26	68	30	10	20	
Гучин-Ус	130	42	88	78	25	53	52	17	35	
Есөн зүйл	131	38	93	72	15	57	59	23	36	
Зүүнбаян-Улаан	148	60	88	79	33	46	69	27	42	
Нарийнтээл	194	78	116	98	40	58	96	38	58	
Өлзийт	120	42	78	67	19	48	53	23	30	
Сант	151	43	108	109	31	78	42	12	30	
Тарагт	140	41	99	90	23	67	50	18	32	
Төгрөг	160	35	125	90	23	67	70	12	58	
Уянга	356	104	252	210	42	168	146	62	84	
Хайрхандулаан	164	54	110	79	27	52	85	27	58	
Хархорин	646	189	457	354	98	256	292	91	201	
Хужирт	261	62	199	132	25	107	129	37	92	

Хүснэгт 3. Үндэсний бичгийн мэдлэг, төрийн албаны ангилал, албан тушаалын төрөл, төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын ангилал, хүйсээр

	Бүгд			Маш сайн			Сайн		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	5794	1625	4169	311	45	266	710	132	578
Төрийн улс төрийн алба	329	219	110	11	5	6	36	20	16
Төрийн захиргааны алба	648	215	433	29	7	22	90	18	72
Төрийн тусгай алба	80	33	47	1	0	1	7	1	6
Төрийн үйлчилгээний алба	4737	1158	3579	270	33	237	577	93	484
Бүгд	5794	1625	4169	311	45	266	710	132	578
Удирдах	566	272	294	36	9	27	92	30	62
Гүйцэтгэх	3537	835	2702	245	27	218	540	85	455
Туслах	1691	518	1173	30	9	21	78	17	61
Бүгд	648	215	433	29	7	22	90	18	72
Эрхэлсэн түшмэл	9	5	4	0	0	0	1	1	0
Ахлах түшмэл	87	42	45	2	1	1	14	6	8
Дэс түшмэл	357	99	258	16	4	12	52	8	44
Туслах түшмэл	195	69	126	11	2	9	23	3	20

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Дунд зэрэг			Бага зэрэг			Үгүй, мэдлэггүй		
Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
1706	420	1286	1613	504	1109	1454	524	930
96	61	35	98	69	29	88	64	24
233	74	159	211	85	126	85	31	54
27	11	16	27	13	14	18	8	10
1350	274	1076	1277	337	940	1263	421	842
1706	420	1286	1613	504	1109	1454	524	930
181	86	95	151	87	64	106	60	46
1174	263	911	994	280	714	584	180	404
351	71	280	468	137	331	764	284	480
233	74	159	211	85	126	85	31	54
5	2	3	3	2	1	0	0	0
25	11	14	35	18	17	11	6	5
134	37	97	104	38	66	51	12	39
69	24	45	69	27	42	23	13	10

Хүснэгт 4. Үндэсний бичгийн мэдлэг, сумаар

	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Бага зэрэг	Үгүй, мэдлэггүй	
Бүгд	5794	311	710	1706	1613	1454
Арвайхээр	2130	116	278	636	611	489
Баруунбаян-Улаан	146	8	18	43	47	30
Бат-Өлзий	270	10	33	53	69	105
Баян-Өндөр	168	5	21	53	46	43
Баянгол	147	9	28	45	38	27
Богд	208	9	14	50	62	73
Бүрд	124	6	18	54	33	13
Гучин-Ус	130	12	13	45	35	25
Есөн зүйл	131	10	12	50	31	28
Зүүнбаян-Улаан	148	9	13	40	39	47
Нарийнтээл	194	5	10	53	66	60
Өлзийт	120	8	13	39	32	28
Сант	151	6	35	55	28	27
Тарагт	140	4	21	51	37	27
Төгрөг	160	8	17	43	45	47
Уянга	356	22	28	82	107	117
Хайрхандулаан	164	4	16	55	32	57
Хархорин	646	45	79	176	193	153
Хужирт	261	15	43	83	62	58

Хүснэгт 5. Эхийг уншсан байдал, уншсан үгийн тоо

	Бүгд	Унших чадвар				Уншсан үг бүлэглэсэн				
		Огт уншиж чадаагүй	Зарим хэсгийг унших чадвартай	Бүтнээр нь унших чадвартай	Бүгд	10 хүртэл	10-20	20-30	30-аас дээш	
Хүйс	Бүгд	4340	471	2211	1658	2211	401	726	600	484
	Эрэгтэй	1101	160	632	309	632	117	217	184	114
	Эмэгтэй	3239	311	1579	1349	1579	284	509	416	370
Насны бүлэг	Бүгд	4340	471	2211	1658	2211	401	726	600	484
	15-19	5	1	4	0	4	1	0	2	1
	20-24	200	16	126	58	126	19	47	35	25
	25-29	655	98	358	199	358	65	131	108	54
	30-34	890	96	492	302	492	93	163	121	115
	35-39	795	37	361	397	361	44	113	92	112
	40-44	621	35	248	338	248	40	66	72	70
	45-49	578	62	298	218	298	65	90	77	66
	50-54	376	79	197	100	197	52	65	52	28
	55-59	179	39	105	35	105	17	44	33	11
	60-64	28	7	15	6	15	4	4	5	2
	65-69	7	1	5	1	5	1	3	1	0
	70+	6	0	2	4	2	0	0	2	0

Хүснэгт 6. Үндэсний бичгийн бичих чадвар, төрийн албаны ангилал, төрлөөр

	Бүгд	Тийм, сайн бичиж чадна	Тийм, дунд зэрэг бичиж чадна	Тийм, бага зэрэг бичиж чадна	Үгүй, бичиж чадахгүй
Бүгд	4340	572	1597	1747	424
Төрийн улс төрийн алба	241	22	79	115	25
Төрийн захиргааны алба	563	65	219	225	54
Төрийн тусгай алба	62	1	23	32	6
Төрийн үйлчилгээний алба	3474	484	1276	1375	339
Бүгд	4340	572	1597	1747	424
Удирдах	460	68	175	183	34
Гүйцэтгэх	2953	436	1145	1106	266
Туслах	927	68	277	458	124
Бүгд	563	65	219	225	54
Эрхэлсэн түшмэл	9	1	5	3	0
Ахлах түшмэл	76	5	30	32	9
Дэс түшмэл	306	38	124	116	28
Туслах түшмэл	172	21	60	74	17

Хүснэгт 7. Үндэсний бичгийн бичих чадвар, сумаар

	Бүгд	Тийм, сайн бичиж чадна	Тийм, дунд зэрэг бичиж чадна	Тийм, бага зэрэг бичиж чадна	Үгүй, бичиж чадахгүй
Бүгд	4340	572	1597	1747	424
Арвайхээр	1641	213	615	644	169
Баруунбаян-Улаан	116	16	37	52	11
Бат-Өлзий сум	165	24	64	69	8
Баян-Өндөр	125	13	45	43	24
Баянгол	120	15	52	47	6
Богд	135	17	44	57	17
Бүрд	111	19	32	54	6
Гучин-Ус	105	15	44	34	12
Есөн зүйл	103	12	49	33	9
Зүүнбаян-Улаан	101	14	23	56	8
Нарийнтээл	134	10	42	62	20
Өлзийт	92	13	35	38	6
Сант	124	20	66	35	3
Тарагт	113	13	50	40	10
Төгрөг	113	13	33	62	5
Уянга	239	32	79	102	26
Хайрхандулаан	107	11	47	38	11
Хархорин	493	59	169	204	61
Хужирт	203	43	71	77	12

Хүснэгт 8. Эхийг уншсан байдал, уншсан үгийн тоо, төрийн албаны ангиллаар

	Унших чадвар				Уншсан үг бүлэглэсэн				
	Бүгд	Огт уншиж чадаагүй	Зарим хэсгийг унших чадвартай	Бүтнээр нь унших чадвартай	Бүгд	10 хүртэл	10-20	20-30	30-аас дээш
Бүгд	4340	471	2211	1658	2211	401	726	600	484
Төрийн улс төрийн алба	241	34	135	72	135	34	42	37	22
Төрийн захиргааны алба	563	50	315	198	315	48	103	86	78
Төрийн тусгай алба	62	6	41	15	41	7	10	11	13
Төрийн үйлчилгээний алба	3474	381	1720	1373	1720	312	571	466	371
Бүгд	4340	471	2211	1658	2211	401	726	600	484
Удирдах	460	44	216	200	216	42	54	63	57
Гүйцэтгэх	2953	283	1436	1234	1436	236	474	392	334
Туслах	927	144	559	224	559	123	198	145	93

Хүснэгт 9. Эхийг уншсан байдал, сумаар

	Бүгд	Огт уншиж чадаагүй	Зарим хэсгийг унших чадвартай	Бүтнээр нь унших чадвартай
Бүгд	4340	471	2211	1658
Арвайхээр	1641	199	812	630
Баруунбаян-Улаан	116	24	50	42
Бат-Өлзий	165	16	92	57
Баян-Өндөр	125	16	57	52
Баянгол	120	7	53	60
Богд	135	16	78	41
Бүрд	111	6	54	51
Гучин-Ус	105	12	50	43
Есөн зүйл	103	16	39	48
Зүүнбаян-Улаан	101	8	62	31
Нарийнтээл	134	25	75	34
Өлзийт	92	8	50	34
Сант	124	8	68	48
Тарагт	113	6	62	45
Төгрөг	113	9	60	44
Уянга	239	34	133	72
Хайрхандулаан	107	6	56	45
Хархорин	493	41	264	188
Хужирт	203	14	96	93

Хүснэгт 10. Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байгаа эсэх, хамрагдах хүсэлтэй төрийн албан хаагчдын тоо

Насны бүлэг	Сургалтын хэрэгцээ, шаардлага байгаа эсэх				Сургалтын хэлбэр							
	Бүгд	Онлайн сургалт	Танхимын сургалт	Үгүй	Бүгд	Онлайн сургалт	Танхимын сургалт	Бусад хэлбэрийн сургалт	Онлайн болон танхимын сургалт	Онлайн болон бусад хэлбэрийн сургалт	Танхимын болон бусад хэлбэрийн сургалт	
Насны бүлэг	Бүгд	5794	5101	693	5101	1150	3464	34	439	3	11	
	15-19	6	6	0	6	1	5	0	0	0	0	
	20-24	230	217	13	217	55	126	0	36	0	0	
	25-29	812	756	56	756	183	489	2	81	0	1	
	30-34	1077	1005	72	1005	222	670	8	102	0	3	
	35-39	924	800	124	800	203	529	2	64	1	1	
	40-44	782	683	99	683	150	482	6	40	0	5	
	45-49	763	652	111	652	149	454	8	40	1	0	
	50-54	747	640	107	640	128	463	5	43	0	1	
	55-59	365	287	78	287	55	205	3	23	1	0	
	60-64	67	42	25	42	3	30	0	9	0	0	
	65-69	11	6	5	6	1	4	0	1	0	0	
	70+	10	7	3	7	0	7	0	0	0	0	
	Бүгд	5794	5101	693	5101	1150	3464	34	439	3	11	
	Төрийн улс төрийн алба	329	305	24	305	68	181	2	53	0	1	
	Төрийн захиргааны алба	648	608	40	608	180	346	3	74	1	4	
	Төрийн тусгай алба	80	71	9	71	19	47	0	5	0	0	
	Төрийн үйлчилгээний алба	4737	4117	620	4117	883	2890	29	307	2	6	
	Бүгд	5794	5101	693	5101	1150	3464	34	439	3	11	
	Удирдах	566	514	52	514	141	303	3	65	0	2	
	Гүйцэтгэх	3537	3107	430	3107	747	2062	21	266	3	8	
	Туслах	1691	1480	211	1480	262	1099	10	108	0	1	
	Бүгд	648	608	40	608	180	346	3	74	1	4	
	Эрхэлсэн түшмэл	9	9	0	9	4	4	0	0	0	1	
	Ахлах түшмэл	87	80	7	80	21	47	0	11	0	1	
	Дэс түшмэл	357	338	19	338	105	181	3	46	1	2	
	Туслах түшмэл	195	181	14	181	50	114	0	17	0	0	

Хүснэгт 11. Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байгаа эсэх, хамрагдах хүсэлтэй төрийн албан хаагчдын тоо, сумаар

	Сургалтанд хамрагдах хэрэгцээ, шаардлага			Сургалтын хэлбэр						
	Бүгд	Тийм	Үгүй	Бүгд	Онлайн сургалт	Танхимын сургалт	Бусад хэлбэрийн сургалт	Онлайн болон танхимын сургалт	Онлайн болон бусад хэлбэрийн сургалт	Танхимын болон бусад хэлбэрийн сургалт
Бүгд	5794	5101	693	5101	1150	3464	34	439	3	11
Арвайхээр	2130	1889	241	1889	479	1243	10	152	1	4
Баруунбаян-Улаан	146	131	15	131	44	80	0	7	0	0
Бат-Өлзий	270	239	31	239	41	185	4	9	0	0
Баян-Өндөр	168	149	19	149	34	107	0	8	0	0
Баянгол	147	125	22	125	19	89	4	13	0	0
Богд	208	195	13	195	32	109	1	53	0	0
Бүрд	124	104	20	104	32	53	2	17	0	0
Гучин-Ус	130	115	15	115	37	68	0	8	0	2
Есөн зүйл	131	111	20	111	24	76	1	10	0	0
Зүүнбаян-Улаан	148	134	14	134	17	71	0	46	0	0
Нарийнтээл	194	176	18	176	26	137	3	10	0	0
Өлзийт	120	106	14	106	18	76	0	10	1	1
Сант	151	128	23	128	19	102	1	6	0	0
Тарагт	140	132	8	132	24	102	1	3	0	2
Төгрөг	160	146	14	146	26	108	0	12	0	0
Уянга	356	315	41	315	74	223	2	16	0	0
Хайрхандулаан	164	142	22	142	34	85	0	23	0	0
Хархорин	646	551	95	551	124	391	4	29	1	2
Хужирт	261	213	48	213	46	159	1	7	0	0